

**"ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ" ХХК-ИЙН 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

| № | Хийх ажлын агуулга | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах нэгж, албан тушаалтан |
|----|---|--|----------------------------|---|
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах | 1.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/ | Жилдээ | Мэдээллийн самбар, цахим хуудсанд тухай бүр мэдээлэл, зөвлөмж гаргадаг. ХХААХҮЯ-наас зохион байгуулсан "ИРГЭН ТАНД ЗӨВЛӨӨ" нээлттэй хаалганы өдөрлөг болон ТӨБЗГ-аас зохион байгуулсан “ТӨРИЙН ӨМЧИЙН МЕНЕЖМЕНТ БА НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА-2017” арга хэмжээнд оролцож, таниулга сурталчилгаа хийсэн. |
| 2. | Үйл ажиллагааны орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх, цахим хуудсанд байршуулах | 2.1 Тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин, нэмэлт өөрчлөлт | Жилдээ | ТӨБЗГ-ын 2016.12.20-ны өдрийн 185 дугаар тогтоолоор Биржийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшинг баталсан ба 2017.09.12-ны 365 дугаар тогтоолоор зорилтод түвшинд тодотгол оруулсныг компанийн веб сайтад байршуулсан. Мөн Биржийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин ТӨБЗГ-ын 2017.12.12-ны 649-р тогтоолоор батлагдсаныг компанийн веб сайтад байршуулсан. |
| | | 2.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт | 4 дүгээр сарын 25-ны дотор | Компанийн mce.mn веб сайтад байршуулсан. |
| | | 2.4 Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | 7 дугаар сарын 1-ний дотор | Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан зөрчлүүдийг арилгах төлөвлөгөө гарган, гүйцэтгэлийг ХААХҮЯ, ТӨБЗГ-т хүргүүлсэн. |
| 3. | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй | 3.1 Биржээс олгож буй зөвшөөрөл /суудлын эрх, итгэмжлэгдсэн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрх зэрэг/ эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл | Жилдээ | Биржийн байнгын болон байнгын бус гишүүдийн мэдээллийг цахим хуудсанд байршуулж, мэдээллийг шинэчилж байна. |

| | | | | |
|----|--|--|-----------------------------|---|
| | байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах | олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд байршуулах 3.2 Аливаа үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор бусад байгууллагаас олгосон зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх г.м бусад үйл ажиллагаа эрхлэх/, түүний талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах | Жилдээ | Санхүүгийн зохицуулах хорооноос үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих тусгай зөвшөөрөл авсан талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан. Нэмэгдсэн үйл ажиллагааны чиглэлийг байгууллагын дүрэмд тусгахаар ТӨБЗГ-т холбогдох материалыг явуулсан ба УБЕГ-т бүртгүүлсний дараа олон нийтэд мэдээлнэ. |
| 4. | Удирдлагын шийдвэр болон хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | 4.1 Удирдлагын шийдвэр /Хувь нийлүүлэгчдийн хурлын болон ТУЗ-ийн тогтоол/-ийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/ 4.2 ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал болон эрх бүхий албан тушаалтнуудын товч танилцуулгыг цахим хуудсанд байршуулах | 2 дугаар сар, 5 дугаар сард | Удирдлагын шийдвэр болон ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн танилцуулгыг цахим хуудсанд байршуулж, өөрчлөлт орсон тухай бүр өөрчлөлтийг хийж байна. |
| 5. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | 5.1 Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн үр дүнгийн талаар цахим хуудсанд байршуулах. | Тухай бүр | Хууль зүйн туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулах зарыг цахим хуудсанд байршуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулсан. |
| | | 5.2 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтын хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсанд байршуулах | Тухай бүр | |
| | | 5.3 Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах. | Жилдээ | |
| 6. | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах | 6.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах | 1 дүгээр сард | Хуулийн зөвлөх Г.Туяад ЭБАТ-ны гүйцэтгэх чиг үүргийг давхар хариуцуулж, ажлын байрлын тодорхойлолтод нэмж тусгасан. |

| | | | | |
|----|---|---|---------------|---|
| | | 6.2 Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх | Тухай бүр | 2017 оны 4-р сард АТГ-аас төрийн өмчит компаниудын дунд явуулсан сургалтад хамрагдав. |
| | | 6.3 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх <i>/хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/</i> | Жилдээ | 2017 онд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж, ихэнх албан хаагчдын ажлын байрыг сэлгэн ажиллуулсан. Биржээр арилжаалагдсан барааны тодорхойлолтыг хүсэлт гаргасан тухай бүр нь түргэн шуурхай гаргаж өгч хэвшсэн. |
| | | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх | Жилдээ | АТГ-аас ирсэн шалгалтын ажлын хэсэгт шаардлагатай материал, холбогдох мэдээллээр хангасан. |
| 7. | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх | 7.1 Компанийн Ёс зүйн хороог шинээр байгуулж, дүрмийг шинээр боловсруулж батлуулах. Нийт ажилтнуудад танилцуулах | 2 дугаар сард | Компанийн Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын 2017.02.01-ний өдрийн А/08 тоот тушаалаар шинэчлэн батлав. Мөн Биржийн ажилтны ёс зүйн дүрмийг Гүйцэтгэх захирлын 2017.02.08-ны өдрийн А/10 тоот тушаалаар шинэчлэн баталж, нийт ажилтнуудад танилцуулан гарын үсэг зуруулав. |
| | | 7.2 Зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэж, хамт олонд мэдээлсэн байх | Тухай бүр | Ажлын байранд ёс зүйн зөрчил гаргасан зарим ажилтнуудад Ёс зүйн хорооны зүгээс анхааруулга өгч, сахилгын арга хэмжээ авхуулах талаар Гүйцэтгэх захиралд танилцуулав. |
| 8. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | 8.1 Засгийн газар, яамд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр | Тухай бүр | Биржийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох шийдвэрүүдийг компанийн цахим хуудсанд байршуулж байна. |
| | | 8.2 Нэмэлт өөрчлөлт орсон компанийн дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, заавар | Тухай бүр | Компанийн холбогдох дүрэм журмыг цахим хуудсанд байршуулж байна. |
| 9. | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт | 9.1 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга <i>/уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/</i> -д нэгдсэн байдал | Жилдээ | ХААХҮЯ, ТӨБЗГ-аас зохион байгуулж буй ажил, арга хэмжээнд тухай бүр оролцож байгаа. |
| | | 9.2.Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх <i>/зарцуулалт/</i> | Жилдээ | 1,5 сая төгрөг төлөвлөж, тухай бүр зарцуулсан. |

| | | | | |
|--|--|---|--------|---|
| | | 9.3 Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах | Жилдээ | Сар бүр хэлтэс дотор сургалт зохион байгуулдаг. |
|--|--|---|--------|---|

__oOo__